



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 1/02


Амардалай

Ажил албан тушаалын цалин нэмэгдлийг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дүгээр зүйлийн 67.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн Албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.1, 57.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай" 488 дугаар тогтоол, 2022 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, 2022 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны "Захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай" А/17 дугаар захирамж, "Үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг нэмэгдүүлэх тухай" А/18 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. ЗДТГ-ын албан хаагчдын цалин нэмэгдлийг хавсралтаар баталсугай
2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг улирлаар дүгнэж, үр чадварын нэмэгдлийг сар бүр 10-25 хувиар олгосугай.
3. Албан хаагчдын албан тушаалын цалин, нэмэгдлийг хавсралтад заасны дагуу 2023 оны 01 дүгээр 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.НАРАНТУНГАЛАГ

488001572